

***Илтгэгч: О.Номуулин Монголын Хуульчдын холбооны Хуульчийн мэргэжлийн дүрэм, ёс зүйн асуудал эрхэлсэн хорооны гишүүн, Шүүхийн сахилгын хорооны гишүүн***

Сайн байцгаана уу? Энд хуран цугларсан эрхэм хүндэт ноёд хатагтай та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Өнөөдрийн миний илтгэлийн сэдэв “Олон нийтийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд шүүгчийн ёс зүйн гүйцэтгэх үүрэг”. Илтгэлээ эхлэхээс өмнө Нээлттэй Нийгэм Форум болон Оюуны инновац Төрийн бус байгууллага хамтраад гаргасан шүүхийн индексийг та бүхэнд харуулъя. Энэ судалгааны талаар Д.Зүмбэрэллхам гишүүн тодорхой ярилаа. Үүнийг та бүхэнд харуулахын гол учир бол энэ судалгаагаар шүүхэд итгэх олон нийтийн итгэл 53.17% гэж гарсан ч “шүүгчийн ёс зүй ба хариуцлага” гэх дэд сэдвийн хүрээнд үнэлгээ 45.17% гэж гарсан байна. Миний хувьд энэ судалгааг их сайн хийгдсэн судалгаа гэж үздэг бөгөөд энэ судалгаанаас харахад шүүгчийн ёс зүй сахилга хариуцлагын талаар олон нийтийн итгэл нэлээн доогуур байгаа нь харагдаж байна гэсэн дүгнэлтэд өөрийн эрхгүй хүргэж байгаа юм.

Нөгөө талаас Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичиг болох “Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-д 2040 он гэхэд иргэдийн итгэлийг бүрэн хүлээсэн шүүхтэй болно гэсэн тод томруун зорилт тавьсан. Тэгэхлээр Монгол улсын хөгжлийн бодлогын баримт бичигт тодорхойлсон зорилтдоо хүрэх шаардлага гарч ирнэ. Бодит байдал дээр шүүхэд итгэх олон нийтийн итгэл харьцангуй доошилж байгаатай холбоотойгоор зайлшгүй олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх нь зүй ёсны хэрэг юм. Үүнийг нэмэгдүүлэхэд шүүгчийн ёс зүй ямар үүрэгтэй вэ? гэдэг талаас илтгэлээ чиглүүллээ.

Аливаа мэргэжлийн ёс зүй нь тухайн мэргэжлийн өөрийн үүргээс урган гардаг, өөрөөр хэлбэл ажлын онцлогоос нь хамаараад өөр өөр стандарт тогтоох шаардлагатай байдаг бөгөөд мэргэжлийн ёс зүй дотроос хамгийн өндөр шаардлага тавигдах нь шүүгчийн ёс зүй байдаг.

Учир нь шүүгчийн ёс зүй бол шүүгч албан ажилдаа болон хувийн амьдралдаа биеэ хэрхэн авч явах, нийгмийн итгэл хүндлэлийг хүлээхийн тулд, түүнийг хадгалж явахын тулд шүүгчийн хариуцлагыг хэрхэн ухамсарлаж ойлгохтой холбоотой ойлголт юм. Ийм учраас бусад мэргэжлийн ёс зүйгээс өндөр шаардлага тавигддаг гэж хэлж байгаа юм. Тэгэхээр шүүх эрх мэдэл олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөх үндэс нь Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн хүчин чадал байхаас гадна шүүгчид шүүн таслах чиг үүргээ шударгаар, хараат бусаар, хүртээмжтэй байдлаар хэрэгжүүлсний үндсэн дээр олж авсан иргэдийн итгэл хүндлэл байдаг.

Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ гэж заасан. Энэхүү шүүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг шүүхийн нэр хүнд хамгийн гол нь шүүгчийн нэр хүндтэй холбоотой. Тэгэхээр шүүгчийн нэр хүндийг тодорхойлдог гол зүйл нь ёс зүй. Өөрөөр хэлбэл шүүгчийн нэр хүндийг ариун байлгах гол нөхцөл нь шүүгч хүн ёс зүйн хэм хэмжээгээ сахин биелүүлэх явдал байдаг. Иймд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын зарчимд нийцсэн бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдөхүйц шүүгчийн зохих ёс зүйн стандартыг баталж мөрдүүлэх нь зайлшгүй ач холбогдолтой гэдгийг олон улсад хүлээн зөвшөөрдөг.

Шүүгчийн ёс зүйн талаарх Банглорын зарчмуудын оршил хэсэгт “Шүүхийн тогтолцоо, шүүгчийн ёс зүй, шударга байдалд итгэх олон нийтийн итгэл нь орчин үеийн ардчилсан нийгмийн амин сүнс болж байна. Шүүн таслах ажлыг олон нийтийн зүгээс хүлээлгэсэн итгэл хэмээн ойлгож, дээдлэн хүндэлж, шүүгчид дангаараа болон хамтдаа шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг хадгалж, бэхжүүлж байх нь зайлшгүй чухал юм” гэж тодорхойлжээ.

Шүүгчид тавих ёс зүйн стандарт нь шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаанд болон хувийн зан суртахуунд тавигдах шаардлагаас бүрддэг.

Мэргэжлийн үйл ажиллагаанд тавигдах ёс зүйн шаардлага нь хараат бус байх, шударга байх, төвийг сахих, хичээл зүтгэл ба мэргэжлийн чадамжтай байх зарчмуудыг агуулдаг бол хувийн зан суртахуунд тавих шаардлага нь хүнлэг байх, эр зоригтой шийдэмгий байх, бодитой ухаалаг хандах, харилцааны ур чадвартай байх чадамж, зан чанаруудыг багтааж болно.

Дээрх мэргэжлийн үйл ажиллагаанд болон хувийн зан суртахуунд тавигдах зарчмуудыг хэлбэрэлтгүй дагаж мөрдөж чадвал шүүгч сахилгын зөрчилд холбогдохгүй байх ач холбогдолтой.

Шүүгчийн сахилгын зөрчлийн маргаан нь маргааны талуудад нотлох үүрэг хүлээлгэдэг хувийн эрх зүйн маргаан биш, харин нийтийн ашиг сонирхол хөндөгддөг нийтийн эрх зүйн маргаан учир шүүгч сахилгын зөрчил гаргасан асуудал нь шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг үгүй хийдэг ноцтой үр дагавартай.

Дээр дурдсан зарчмуудыг 15-20 минутад ярих боломж байхгүй болохоор мэргэжлийн үйл ажиллагаанд тавигдах ёс зүйн шаардлагаас “хичээл зүтгэл ба мэргэжлийн чадамжтай байх” зарчим, хувийн зан суртахуунд тавигдах ёс зүйн шаардлагаас “харилцааны ур чадвартай байх” гэсэн зарчмыг илүү тодруулж ярихыг хүслээ.

Яагаад энэ 2-ыг сонгож авсан юм бэ гэхээр ер нь сахилгын хороонд ирж байгаа өргөдөл мэдээллийн агуулгаас үзэхээр шүүгчийн мэргэжлийн ур чадвар, хичээл зүтгэлтэй байх зарчмыг зөрчсөнтэй холбоотой дийлэнх өргөдөл мэдээлэл ирж байгаа учраас эдгээр ойлголтууд дээр тогтож ярих нь зөв гэж үзэж байна. Эдгээр зарчмыг зөрчихгүйн тулд шүүгч нар хэрхэн биеэ авч явах ёстой, үйл ажиллагаагаа хэрхэн зохицуулах ёстой вэ гэдэг дээр тулгуурлаж ярья.

Шүүгчийн ёс зүйн дүрмийн хэм хэмжээ стандарт манай улсад 1954 оноос хойш мөрдөгдөж байсан гэж үзэж болно. Шүүгчдийн сахилга батын хариуцлагын тухай дүрэм 1954 онд байсан бол БНМАУ-ын шүүгч нарын сахилга батын хариуцлагын дүрэм 1970 онд байсан байна. Ардын шүүгчийн ажил мэргэжлийн ёс зүйн зарчим, төр ард түмний өмнө хүлээх үүрэг хариуцлага гээд 1989 онд батлагдаж байсан бол 1997, 2003, 2010, 2014 онуудад Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм батлагдаж шүүгч нар маань энэхүү дүрэмд захирагдан өдөр тутмын үйл ажиллагааны стандартыг тогтоож байжээ.

Харин 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс Монгол Улсын Шүүхийн тухай хууль мөрдөгдөж эхэлснээр шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг дүрмээр биш хуулиар нэрлэн зааж, ёс зүйн хэм хэмжээг сахилгын зөрчил хэмээн нэр томъёогоор илэрхийлэх болсон.

Хэдийгээр шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг дүрмээр тогтоож, түүнийг зөрчвөл хариуцлага хүлээлгэхээр хуулийн зохицуулалт одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын Шүүхийн тухай хуульд байхгүй ч энэ хуулиар нэрлэн заасан зөрчлийн хэм хэмжээ нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шүүгчийн ёс зүйн зарчмуудад үндэслэж тодорхойлогдсон гэж ойлгохоор байна.

Ийм ч учраас энэ төслийн хүрээнд Канадаас ирсэн шүүгч нар маань туслалцаа үзүүлж, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, ахмад шүүгч нар маань харилцан хамтран ажиллаж “Шүүгчийн ёс зүйн хөтөч” гэсэн гарын авлагыг боловсруулахаар ажиллаж байгааг та бүхэнд дуулгамаар байна. Дүрэм байхгүй, дүрмээр тогтоосон ёс зүйн хэм хэмжээ байхгүй гэдэг утгаараа шүүгч хүн өнөөдөр өдөр тутам шүүн таслах эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ болон хувийн амьдралдаа ямар стандарт дагаж мөрдөхөө мэдэхгүй явна гэж байхгүй шүү дээ. Нэгэнтээ Монгол

улсын шүүх олон улсын шүүгчдийн холбооны гишүүн бөгөөд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шүүгчийн ёс зүйн зарчмыг дагаж мөрдөх үүрэгтэй учраас шүүгч нар ёс зүйн хэм хэмжээгээ зайлшгүй дагаж мөрдөх үүрэгтэй гэдгийг тодруулж хэлмээр байна.

Шүүгчийн хичээл зүтгэл гэсэн зарчмын хэсэгтээ оръё. Хичээл зүтгэл бол харьцангуй утгатай ойлголт. Өдөр тутмын ажилдаа нухацтай хандаж мэргэжлийн үүргээ идэвхи зүтгэлтэй гүйцэтгэх, албан үүргээ амжуулахын тулд тууштай чармайх гэж тодорхойлж болно.

АНУ-ын Иллинойс мужийн Дээд шүүхээс “Шүүгч шүүгчийн үүргээ гүйцэтгэхдээ чамбай байх хэрэгтэй. Маргалдагч талууд, тангарагтнууд, өмгөөлөгчдийн хэн хэнийх нь хувьд цаг хугацаа бол үнэтэй зүйл. Тэрээр өөртөө чамбай зан, хичээл зүтгэлийг дадал болгон төлөвшүүлээгүй бол шүүхийн үйл ажиллагаанд сэтгэл ханамжгүй байдлыг үүсгэдэг” гэж тодорхойлсон бол Банглорын зарчмын тайлбарын 193 дахь хэсэгт “Эрүүл ухаанаар хандаж төвийг сахиж шийдвэрлэх, шуурхай байх нь шүүхийн хичээл зүтгэлийн бүх тал юм. Хичээл зүтгэлтэй байдалд төвийг сахихыг хичээх, хуулийг чанд сахиулах, шүүхийн процессыг урвуулан ашиглахаас сэргийлэх зэрэг хамаарна...”, 6.5-д “Шүүгч нь шүүн таслах ажиллагааг үр бүтээлтэй, шударгаар, аль болох хурдан шуурхай шийдвэр гаргахад чиглүүлнэ” гээд хэрэг маргааныг талуудын эрхийг харгалзан үзсэний үндсэн дээр шаардлагагүй илүү зардал гаргалгүй, хойшлуулалгүйгээр түргэн шуурхай шийдвэрлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч бүрийг тэвчээртэй сонсох, тогтоосон хуралдааны цагийг хатуу мөрдөх, гаргасан шийдвэрийн үндэслэлээ хэвлэмэл байдлаар аль болох хурдан хүргүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар мэдээлэл авах ил тод байдлын тогтолцоог бий болгох үүрэгтэй талаар тайлбарласан байна.

Харин Канадын шүүгчийн ёс зүйн зарчимд шүүгч нь хичээл зүтгэлээ дайчлан мэргэжлийн чадамжтайгаар албан үүргээ хэрэгжүүлэхийг үүрэг болгосон бол Монгол Улсын Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.7-д “Хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа чин сэтгэлээсээ хандах бөгөөд хүчин чармайлт гаргаж, шуурхай зохион байгуулалттай ажиллана” гэснээс үзвэл шүүгч хичээл зүтгэлтэй ажиллахын тулд ажилдаа чин сэтгэлээсээ хандаж, чармайж, зохион байгуулалттай, шуурхай ажиллах зэрэг хэд хэдэн дадлыг эзэмшсэн байх хэрэгтэй гэдэг нь ойлгогдож байна.

Шүүгч хүн шүүх хуралдааныг тогтоосон цагтаа нээдэг, хуралдааны цагийг хатуу мөрддөг байх хэрэгтэй. Гаргасан шийдвэрийнхээ үндэслэлийг хэвлэмэл байдлаар аль болох хурдан хугацаанд хүргүүлэхийг эрмэлзэх шаардлагатай байна. Гомдол гаргах хуулийн хугацаа, шүүхийн шийдвэрийг бичиж гаргах хугацаагаа ягштал баримтлах ёстой. Илүү зардал гаргалгүйгээр шүүх хуралдааныг хойшлуулалгүйгээр хэрэг маргааныг шийдүүлэх нь хэргийн оролцогчдод буюу олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг. Гэхдээ шүүх хуралдааныг хойшлуулахад шүүгчээс үл хамаарсан олон хүчин зүйл нөлөөлж байгааг ойлгож байгаа. Тухайлбал, талуудын хүсэлтийг хангадаг, олон хүсэлт гаргадаг, янз бүрийн хүндэтгэн үзэх шалтгаан нэрийдлээр хуралдааныг хойшлуулдаг, өмгөөлөгчийн ёс зүйтэй ч холбоотой прокурорын ёс зүйтэй ч холбоотой ийм олон шалтгаанаар 40-50 удаа хойшилсон ч хурал байдаг.

Тэгэхээр олон шалтгаанаар шүүгч нар хэргийн оролцогчдын эрхийг зөрчихгүйн тулд хуралдааныг хойшлуулдаг ч гэсэн хурдан шуурхай хийхийг эрмэлзэж чармайх ёстой гэдгийг л энэхүү хичээл зүтгэлтэй байх зарчмаар хэлж байгаа юм. Түүнчлэн хийх ёстой ажлаа тууштай тогтвортой хийх ёстой шүү. Ямар нэгэн эсэргүүцэл, бэрхшээл, таагүй байдлаас үл хамаараад тэр олон нийтийн санаа бодлоос үл хамаараад тухайн хуваарилагдаж ирсэн хэрэг маргаанаа зөвхөн

хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй л гэж байгаа юм.

Өнөөдөр шүүхийн гадаа олон нийт жагсаад онц хүнд гэмт хэрэгт холбогдсон хүнийг яллаж шийтгэ гэж орилж байхад дотор нь шүүгч хэргийн нотлох баримтаа шинжлэн судалж, хуульд заасан үүргийнхээ дагуу цагаатгах чадвартай байх ёстой. Олон нийтийн санаа бодол, сошиал, хэвлэл мэдээллээр гарч байгаа аливаа эсэргүүцэлд нийцүүлэх гэж хэрэг маргааныг шийдвэрлэх ёсгүй бөгөөд өнөөдөр шүүгчийн тууштай байдал нь ёс зүйн шилдэг дүр төрхийг илтгэдэг. Энэ огтлолцол дээр шүүгчийн ёс зүйн үнэт чанар танигдах учиртай. Шүүгч хүн бүх хуваарилагдсан хэрэгтээ чин сэтгэл гаргадаг, ажлаа хугацаанд нь амжуулахын төлөө шуурхай чармайдаг, ажлын цагаа ягштал баримтлахаас гадна ажлын бус цагаар ажиллах тийм идэвх зүтгэлийг илэрхийлдэг.

Ийнхүү шүүгч шийдвэрлэж байгаа бүх хэрэгтээ чин сэтгэл гаргаж, ажлаа хугацаанд нь чанартай гүйцэтгэхийн тулд хүчин чармайлт гаргаж, зохион байгуулалттай шуурхай ажиллах нь талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шударга ёсыг тогтоох, тухайн шүүгчид төдийгүй шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, шүүхийн нэр хүндийг дээшлүүлэх урьдач нөхцөл болдог байна.

Дээрхээс үзвэл Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.24."хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр албан ажлаа удаа дараа таслах", 50.1.25."шүүх хуралдаан, урьдчилсан хэлэлцүүлгийн товыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа зөрчих", 50.1.26."шүүхийн шийдвэр гаргахтай холбоотой хуульд тодорхой заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа 30 хоногоос дээш хугацаагаар, эсхүл нэг удаа 60 хоногоос дээш хугацаагаар зөрчих" гэж заасан зөрчлүүд нь шүүгч үүрэгт ажилдаа чин сэтгэлээсээ хандаж, шуурхай ажиллах, хуулийн хугацааг баримтлах зэрэг хичээл зүтгэлтэй байх зарчмыг зөрчсөнтэй холбогдож байна.

Дараа нь шүүгчийн мэргэжлийн ур чадамжтай холбоотой асуудал руу оръё.

Банглорын зарчим Үнэт зүйл 6 "Шүүх эрх мэдлийг зохистой хэрэгжүүлэх угтвар нөхцөл нь шүүгч ур чадвартай, хичээл зүтгэлтэй байх явдал мөн": 6.1 "Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх нь шүүгчийн нэн тэргүүний үүрэг юм", 6.3 "Шүүгч нь мэдлэг, ур чадвар, хувийн чанарыг дээшлүүлэх, сайжруулах зохих арга хэмжээг тухай бүр авах бөгөөд энэ зорилгоор шүүгчийн албан үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай шүүхийн сургалт, бусад арга хэрэгслийг зохих ёсоор бүтээлчээр ашиглана", 6.4 "Шүүгч нь хүний эрхийн талаар хэм хэмжээ тогтоосон олон улсын гэрээ конвенц, баримт бичиг зэрэг олон улсын эрх зүйн хөгжлийн талаар зохих мэдээлэлтэй байхыг эрмэлзэнэ" гэж, Канадын шүүгчдийн ёс зүйн зарчимд "Шүүгч нь хичээл зүтгэлээ дайчлан мэргэжлийн чадамжтайгаар албан үүргээ хэрэгжүүлнэ" гэж тунхаглаад "Шүүгч нь шүүн таслах чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, нийгмийн нөхцөл байдлын талаарх мэдрэмж, хувийн зан чанар зэргээ сайжруулна" гэж, Монгол Улсын Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.6 дугаар зүйлийн 1-д "Хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хууль зүйн мэдлэг, ур чадвартай байж, нямбай, хариуцлагатай ажиллана", 2-т "Хуульч нь мэргэжлийн өндөр төвшинд үйл ажиллагаа явуулахын төлөө мэдлэг, ур чадвараа тасралтгүй дээшлүүлж, өөрийгөө байнга хөгжүүлэх үүрэгтэй бөгөөд хууль тогтоомж, шүүхийн шийдвэр, эрдэм шинжилгээний бүтээлийг судалж байвал зохино" гэж тус тус заажээ.

Харин бидний дагаж мөрдөх ёстой Монгол Улсын шүүхийн тухай хуульд шүүгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг мэргэшлээ дээшлүүлж байх, жил бүр сургалтад хамрагдах ёстойг үүрэг болгосон байна.

Шүүгчийн ажил бол тухайн шүүгчийн эрх ямба биш, харин олон нийтийн итгэл дээр тулгуурласан эрх мэдэл учраас шүүхийн үүрэгт ажлаа мэргэжлийн түвшинд, хичээнгүй гүйцэтгэх ёс зүйн хариуцлагыг шаарддаг. Иймд шүүгч ур чадвартай байх, тэрхүү чадвараа байнга хөгжүүлж өөрийгөө мэргэшүүлэх үүрэгтэй болохыг дээр дурдсан баримт бичгүүд болон хуулиар тодорхойлж өгчээ.

Шүүгч хүн зөвхөн материаллаг болон процессын хуулиудаас гадна бодит амьдрал дээрх хууль, шүүхийн нөлөөлөл, нийгмийн чухал асуудлуудын хүрээг сайн мэддэг өргөн мэдлэгтэй байх нь шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг байна.

Мэргэжлийн ур чадвартай холбоотой яригдах гол чухал зүйл бол хууль тайлбарлан хэрэглэх чадвартай байх ёстой. Хууль тайлбарлан хэрэглэхдээ шүүгч шударга ёсыг баримталж, шударга ёсонд захирагдаж тайлбарлана. Энэхүү хууль тайлбарлаж хэрэглэсний үр дүн нь шүүхийн шийдвэр юм. Тэгэхээр энэ мэргэжлийн чадамжтай шүүхийн шийдвэрийг бичих нь өөрөө шууд холбогддог юм байна. Шүүхийн шийдвэрийн үндэслэлээ тодорхой бус бичсэнээс болоод иргэдийн шүүхэд итгэх итгэл маш их буурдаг, нөгөө эргэлзээ, хардлага бий болж олон нийтийн дунд бухимдал бий болдог юм байна. Олон шийдвэрээс харлаа л даа. Үйл баримтаа эхлээд дурдаад үүний дараа хэдэн хуулийн зохицуулалт хуулж бичээд нэхэмжлэлийг хангах нь зөв, хэрэгсэхгүй болгох нь зөв байна гээд биччихдэг. Тэгэхлээр гол тэр хуулийн зохицуулалтаа бичсэн дараа тухайн маргааны үйл баримт энэ хуулийн зохицуулалтад хэрхэн таарч, шаардах эрх үүсгэж байгаа юм уу үүсгэхгүй юм уу гэдгээ дүгнэхгүйгээр шүүхийн шийдвэр гаргаснаас болоод ойлгомжгүй, тодорхойгүй болдог, энэ нөхцөл байдал өөрөө олон нийтийг бухимдуулдаг, итгэлийг нь бууруулаад байгаа нэг шалтгаан болж байгааг шүүгч нартаа хэлэхийг хүслээ.

Хууль тайлбарлан хэрэглэх бол шүүгчийн гол эрх мэдэл. Тэрхүү хуулийг дотоод итгэл үнэмшлээрээ хэрхэн ойлгож, тайлбарлаж, хэрэглэх нь тухайн шүүгчийн үнэлэмж, гэхдээ зүгээр дур зоргоороо тайлбарлаад байгаарай, шүүгчийн хараат бус нэрийн дор өөрт ашигтай байдлаар тайлбарлаад байгаарай гэсэн ойлголт биш. Өөрөөр хэлбэл шүүгчийн хариуцлагагүй байдлыг дэвэргэж байгаа явдал биш юм аа.

Өмнөх ёс зүйн дүрэмд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн мэргэжил ур чадвар, дадал туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд тооцогдохгүй гэж байсан. Энэ зарчим их олон улсад байдаг, Канад улсын шүүгчийн ёс зүйн зарчимд ч байдаг юм байна. Гэхдээ хэтэрхий илт ойлгомжтой хуулийн заалтыг илтэд буруу тайлбарлаж дур зоргоороо авирласан байдлыг сахилгын зөрчилд хамааруулж ойлгодог. Мэргэжлийн ур чадвартай холбоотой Шүүхийн тухай хуульд орсон 3 зөрчлийн хэм хэмжээ байна. 50.1.23 “хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргах”, 50.1.27 “шүүхийн шийдвэрт үндэслэл огт бичээгүй нь дээд шатны шүүхээр тогтоогдсон”, 50.1.40 “Энэ хуулийн 66.7-д заасныг биелүүлээгүй /иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг шүүхийн шийдвэртээ бичээгүй/” гэх заалтууд нь шүүгч мэргэжлийн ур чадамжтай байх, өөрийгөө мэргэшүүлж хөгжүүлэх зарчимд суурилсан хэм хэмжээ гэж ойлгогдож байна.

Сахилгын хороонд ирж байгаа өргөдөл мэдээлэл төдийгүй сахилгын шийтгэл хүлээсэн шүүгчдийн тавиас илүү хувь нь хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсвэл удаа дараа зөрчсөн, эс үйлдэхүй гаргах гэдгээр буруутгагдаж шийтгэл хүлээсэн байна. Хүчин төгөлдөр болчихсон байгаа учраас нийтэд илэрхий, чөлөөтэй ярьж байгаа шүү. Жишээлбэл: гомдол гаргах эрхтэй захирамжид гомдол гаргах эрхгүй гээд заачихдаг, хугацааг нь буруу тооцоод давж заалдах гомдлыг нь авахгүй, эсхүл хуульд заагаагүй шаардлага тавиад гомдлыг нь хүлээж авахаас татгалздаг гэх мэт.

Хамгийн сүүлд шүүгчийн харилцаа хандлагын талаар хэлэхийг хүслээ.

Канадын шүүгчдийн ёс зүйн зарчимд “Шүүгч нь шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг хадгалах, бэхжүүлэхийн тулд зарчимч, хүндэтгэл төрүүлэхүйц байдлаар биеэ авч явна” гэж тунхаглаад “Шүүгч нь шүүх хуралдааны танхимын дотор болон бусад орчинд энгийн дундаж, мэдлэг мэдээлэл бүхий иргэний зэмлэл, шүүмжид өртөхөөргүй хэмжээнд хууль журмыг сахиж, биеэ авч явбал зохино”, “Шүүгч нь албан үүргээ хэрэгжүүлэхдээ хүн нэг бүртэй хүндэтгэлтэй, эелдэг боловсон харилцана”, “Шүүгч нь хамтран зүтгэж буй шүүгчид ёс зүйн зарчмыг сахин мөрдөх явдлыг уриалан дэмжинэ.” гэсэн бол Банглорын зарчимд “Шүүгч нь хувийн амьдралдаа болон олон нийтийн дунд биеэ авч явахдаа өөртөө өндөр стандарт тавих шаардлагатай”, “Шүүгч нь бүрэн эрхийн хугацаандаа бусдад үлгэр жишээ болохуйц амьдрах хэрэгтэй” гэж заажээ.

Шүүгч бол хуульчдын дунд үлгэр дуурайл болох хүн бөгөөд шүүхийн ажилтнууд төдийгүй шүүхээр үйлчлүүлж байгаа хүн бүрийн хувьд биеэ авч явах уур амьсгалыг бүрдүүлдэг. Шүүгчийн энэхүү харилцаа нь олон нийтийн итгэлийг хадгалахад голлох үүрэг гүйцэтгэдэг байна.

Шүүгчийн зан төлөв нь хүндлэл хүлээх, тайван байх, бусдыг ойлгодог, тэвчээртэй, хүлээцтэй, шийдэмгий зэрэг зан чанарыг өөртөө агуулсан байхыг шаарддаг. Энэ зан чанаруудыг шүүгч хүн өөртөө төлөвшүүлэхийн тулд чармайх ёстой. Хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг тухайн шүүгчийн харилцааны ур чадваргүйгээр төсөөлөхийн аргагүй. Шүүгчийн харилцаа хандлагатай холбоотой маш их гомдол ирж байна. Бусдыг алагчлаад байгаа юм шиг гадуурхаад байгаа ч юм шиг эсвэл нэг талд давуу байдал олгоод байгаа юм шиг, хэрэг маргааныг урьдчилан шийдвэрлээд дүгнэлт гаргасан мэт тийм ойлголт төрүүлэхүйцээр үг хэллэг хэрэглэдэг, биеийн хэл, зан үйл, нүдний харц, дуу хоолойны өнгө, үгийн сонголт зэргээсээ болоод хэргийн оролцогчдод хардлага бий болгоод байна.

*Хүндлэл хүлээх чанар.* Эрхэмлэн хүндлэгдэхийн тулд шүүгч нь шүүх хуралдааны танхимд хянан шийдвэрлэх ажиллагааны хэм хэмжээг сахиулж, хянан шийдвэрлэх ажиллагааг хүндэтгэл төрүүлэхүйц, чин шударгаар удирдан явуулах бөгөөд төвийг сахисан, ухаалаг үндэслэлээр нотлогдсон шийдвэр гаргадаг байх ёстой. Түүнчлэн шүүгч эвлэг зантай, тайван атлаа өөртөө бат итгэлтэй байж чадсанаар бусдын хүндэтгэлийг хүлээнэ.

*Тайван байх* гэдэг нь сэтгэлийн түгшүүр, уур хилэн болон сэтгэл хөдлөлийн бусад хүчтэй илрэлүүдэд үл автах, эсхүл харуулахгүй байх чадвар юм. Энгийнээр хэлбэл шүүгчийн үг яриа, үйл хөдлөл дөлгөөн, тогтуун байх ёстой гэсэн үг.

*Бусдыг ойлгодог байх* нь шүүгчид байвал зохих зан төлөвийн чухал чанар. Шүүхийн өмнө буй хэн бүхний мэдрэмж, нөхцөл байдлыг мэдэрч ойлгох, маргаан үүсгэж байгаа асуудал бүр маргалдагч талуудын аль алинд нь чухал гэдгийг хүлээн зөвшөөрөх чадвараар тухайн шүүгч бусдыг ойлгох чадвартай эсэх нь тодорхойлогддог.

*Тэвчээртэй, хүлээцтэй зан чанартай байх.* Тэвчээр гэдэг бол хүнд хэцүү нөхцөлд амархан уурлаж уцаарлахгүй, уурлаж, баярласан ч сэтгэл хөдлөлдөө үл хөтлөгдөх, ил гаргахгүйгээр тэнцвэрээ ямагт хадгалж, тайван байх чадвар юм. Бусадтай тайван, эелдэг харьцаж, маргаантай асуудлаар талуудын байр суурь, саналыг бүрэн сонсож, эргэцүүлэн. тунгааж, үндэслэлтэй бол хүлээн зөвшөөрөхийг эрмэлздэг байхыг шүүгчийн зан төлөв шаарддаг.

*Эелдэг байх* гэдэг нь бусад хүмүүсийг хүнийх нь хувьд (хүний эрхэм чанарыг нь) хүндэлж, бусдын хүсэл, мэдрэмж, бодолд анхааралтай хандаж харьцахыг хэлэх ба бусдыг гомдоохгүй, сэтгэл санаагаар унагахгүй байхыг хичээх явдал юм.

Түүнчлэн тогтуун атлаа тууштай уян хатан гэхдээ шийдвэрт хүрэхийг эрмэлздэг, үүндээ хүрч чаддаг байх өөртөө итгэлтэй боловч биеэ тоосон биш байх ёстой.

*Тогтуун* гэдэг нь амархан уурлаж, сэтгэлээр унахгүй байх чанар.

*Тууштай* гэж өөрийн баримталдаг зарчимд үнэнч, амархан хувирч өөрчлөгддөггүй зан чанарыг хэлнэ.

*Хамтран ажиллах чадвар* шүүгч хүнд нэн шаардлагатай. Хамтран ажиллаж байгаа бусад шүүгчдийн зүгээс гарч байгаа янз бүрийн саналыг ойлгох, хүндэтгэх хэрэгтэй. Хувь хүнийхээ хувьд маргах зүйл аль болох бага байх хэрэгтэй

*Шийдэмгий чанар.* Энэ нь аливаа асуудлыг хурдан, тодорхой шийдэх чадвар юм. Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг урагш явуулахын тулд шүүгч нь эргэлзээ тээнэгэлзэлгүй, итгэл төгс шийдвэрт хүрэх эрмэлзэл, чадвартай байх ёстой.

*Удирдан зохион байгуулах чадвар.* Аливаа ажлыг богино хугацаанд бага цаг хүч зарцуулан, ухаалаг оновчтой аргаар шийдвэрлэхэд бусдын хүч нөөцийг зөв зохицуулан ажиллаж, өөрөө үлгэрлэх замаар өндөр үр дүнд хүргэх чадвар бол шүүгчийн удирдан зохион байгуулах чадварын илрэл билээ.

*Хүмүүстэй харилцах чадвар.* Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг харилцааны ур чадваргүйгээр төсөөлөхийн аргагүй. Мэдээллийг оновчтой аргаар илэрхийлэх, шүүх үйл ажиллагаанд оролцож байгаа талууд бие биеэ зөв ойлгох, эндүү ташаа мэдээлэл өгөхөөс сэргийлэх, нухацтай байх зэрэг нь харилцааны ур чадвараас ихээхэн шалтгаалдаг.

Шүүгч хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ бусдыг алагчлах, гадуурхах байдал гаргаж байгаа мэт ойлголтыг төрүүлэх, хэргийн аль нэг талд давуу байдал олгосон мэт ойлгогдохуйц байдлыг биеийн хэл, харагдах байдал, зан үйлээр илэрхийлэхээс ямагт болгоомжилно.

Тухайлбал, хэргийн болон шүүх хуралдааны оролцогч, өмгөөлөгч, прокурор, иргэдийн төлөөлөгчийг загнах, доромжлох, зохисгүй үг хэллэг хэрэглэх, тухайн хэргийг хэрхэн шийдвэрлэх талаар урьдчилсан дүгнэлт гаргасан мэт ойлголт төрүүлэх асуулт асуух, үг хэлэх, биеэ барихгүй бухимдах, уурлах, зандрах, тэвчээргүй зан гаргах, жигшин зэвүүцсэн байдал, өрөвч сэтгэл гаргах зэрэг харилцаа хандлагаас зайлсхийх ёстой.

Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бусдад хүнлэг бус хандах, хүний нэр төр, ажил хэргийн нэр хүндийг гутаасан шинжтэй үйлдэл гаргаж болохгүй бөгөөд бусадтай харилцахдаа найрсаг, хүндэтгэлтэй, тэвчээртэй, энгийн байх ёстой төдийгүй өөрийн удирдлагад ажиллаж буй бусад этгээдийг дээрх байдлаар бусадтай харилцахыг шаардана.

Жишээ нь, нэхэмжлэгч та нэхэмжлэлийн шаардлагаа тодруулаач? Ямар эрх ашиг чинь зөрчигдөөд байгаа юм бэ гээд асуухад нөгөө хүн нь хууль эрх зүйн мэдлэггүй болохоор хэлж чадахгүй байх тохиолдолд та чинь эрх зүйн чадамжтай эрүүл саруул хүн юм байгаа биз дээ, үүнийгээ тодруулаад хэлэх боломжтой юм байгаа биз дээ гээд л шүүгч хэлчихдэг. Тэгэхээр нөгөө хүн нь энэ шүүгч намайг тэнэг мангар хүн гэлээ, надтай зүй бус харьцлаа гээд гомдол гаргадаг. Ийм учраас шүүгч хүн өөрийнхөө үг яриа, биеийн хэл, тэр дуу хоолойны өнгө, өргөлт, тухайлбал: хэтэрхий их чанга дуугаар ярихаар дээрэлхэж загнаад байна гэх, хэтэрхий сул яриад байхаар хэргийг шударгаар шийдвэрлэх чадвар чадамжгүй юм байна гэх ойлголтыг хэргийн оролцогчдод төрүүлдэг зэргээр үйл хөдлөл, үг яриагаа байнга цэнэж анхаарах хэрэгтэй гэж бодож байна.

Эдгээр шүүгчийн зан төлөвтэй холбоотой стандарт шүүгчийн ёс зүйн Зохистой байдлын зарчимтай холбогдох ба Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 50 дугаар

зүйлийн 50.1.18.“хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах, харилцах”, 50.1.19.”хэргийн оролцогч болон бусад этгээдтэй харилцахдаа шүүхийн нэр хүнд, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлж болох хувийн дотно харилцаа тогтоох”, 50.1.20. “хэргийн оролцогч болон бусад этгээдтэй албан үүргийн хувьд харилцахдаа зүй бус авирлах, эсхүл хуралдааны дэг сахиулах хүрээнд бусдын зүй бус авирыг таслан зогсоох талаар шаардлага тавих үүргээ биелүүлэхгүй байх” гэх мэт зөрчлийн хэм хэмжээний үндэс байж болохоор юм.

Ингээд эцэст нь хэлэхэд шүүгчийн зан байдал, үйл ажиллагаа, шударга байдалд итгэх олон нийтийн итгэлийг бататган бэхжүүлэхэд шүүхийн үйл ажиллагаа нь шударга байгаад зогсохгүй тийнхүү шударга байна гэдгээ батлан харуулах ёстой цаг иржээ. Шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг алдахгүйн тулд шүүгч төдийгүй шүүхийн захиргааны ажилтан, шүүгчийн туслахууд нягт нямбай, чармайх шаардлагатай байна. Шүүхэд итгэх иргэдийн итгэл бат оршиг.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.